

Human Trafficking



Child abduction



Human cage



Forced prostitution



Forced labor



Forced marriage



Organ theft



Selling baby



Forced child beggar



Trafficking boat

“ХҮН ХУДАЛДААЛАХ
ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НЬ”
СУРГАЛТЫН МОДУЛЬ

СУРГАГЧ БАГШ НАРТ
ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨР
(ЭЦЭГ ЭХ, ОЮУТАН
СУРАГЧИД, ОЛОН НИЙТЭД
ЗОРИУЛСАН)

admin

Боловсруулсан: Г.Ганбаясгах (Нийгмийн ажлын магистр)
Т.Цогзолмаа (Хуульзүйн магистр)

МОДУЛИЙН ЗОРИЛГО

Модулийн зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн ерөнхий ойлголт, гэмт хэргийн талаар мэдлэг олгох

СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Суралцагч дараах мэдлэг, чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт, үндсэн нэр томъёо, тайлбар, агуулгыг танин мэдэх;
- Хүн худалдаалах гэмт хэргийн олон улсын тодорхойлолт, ангилал, чиг хандлага, үйлдэл, мөргөлийн арга хэлбэрийн талаар ойлголттой болох
- Хүн худалдаалах гэмт хэргийн зорилго, үйлдэх үе шатны талаар мэдлэгтэй болох
- Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хохирогчийн талаар танин мэдэх; Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох;
- Хүн худалдаалах гэмт хэрэг зохион байгуулалттай гэмт хэргийн хоорондын хамаарлыг тодорхойлох;

СУРГАЛТЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА – 4 цаг

Хичээлийн бэлтгэл

- ✓ Сургалтын танхим, бүлгээр ажиллах боломжтойгоор зохион байгуулах
- ✓ Суралцагчдад тараах материал, бүлгийн ажлын даалгавар, гүнзгийрүүлэн судлах эх сурвалжийн жагсаалт, холбогдох хууль тогтоомжийг олшруулж бэлтгэх
- ✓ Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн,

Модуль 1: Хичээлийн төлөвлөгөө

Хичээлийн сэдэв	Агуулга	Үргэлжлэх хугацаа
Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт	МУ-ын Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл, УДШ-ийн тайлбаруудаас тодорхойлолтыг дэлгэрүүлэн тайлбарлах	40 минут
ОУ-ын конвенцийн талаар	НҮБ-ын Палермогийн протоколд заасан тодорхойлолт, өөрийн улсын хууль тогтоомжтой харьцуулах	20 минут
ХХГХ-ийн үйлдэгдэх үе шат	Элсүүлэлт, тээвэрлэлт, дамжуулах, нуугдуулах, хүлээн авах үйлдэл- Бүлгийн ажил	20 минут 30 минут
Мөлжлөгийн төрлүүд	Хүний мөлжих хэлбэрүүд, мөлжлөгийн төрлүүдийн талаар ЭХ, ОУ-ын конвенцид тулгуурлан тайлбарлах	30 минут
ХХГХ-ийн хохирогч	Хохирогч гэж хэн бэ? Хэрхэн танин мэдэх, илрүүлэлт, одоогийн нөхцөл байдлын талаар тоо мэдээнд тулгуурлан тайлбарлах	40 минут
ХХГХ, зохион байгуулалттай гэмт хэргийн хоорондын хамаарал	ХХГХ яагаад зохион байгуулалттай гэмт хэргийн нэг болох талаар	20 минут
Дүгнэлт	Сургалтыг дүгнэж, ерөнхий ойлголтуудаа нэгтгэх	20 минут

СУРГАЛТЫН АГУУЛГА:

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

ХХГХ-ийг орчин үеийн боолчлол гэж нэрлэдэг. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүч хэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Протокол (Палермо протокол)-уудад мөлжлөг гийн олон төрлийн ойлголтуудыг хамааруулан эдгээр хүчээр хийлгэж буй үйлчилгээнүүд, ялангуяа сайн дурын бус боолчлолын байдал, боолчлол ба түүнтэй ижил төстэй нөхцөлүүд, өрийн дарамтанд оруулан зарцлах болон албадан хөдөлмөрийн талаар тус тус тодорхойлсон байдаг.

Манай улс 2002 оны Эрүүгийн хуулинд анх удаа оруулан хуульчилсан бөгөөд үүнээс хойш нэлээд олон удаагийн өөрчлөлт оруулсан байдаг. 2008 онд УДШ-ээс ЭХ-ийн 113-р зүйлийг тайлбарласан¹ тогтоолыг батлан гаргаснаар хуулийн нэр томъёоны талаар нэг мөр ойлголттой болох боломж бүрдсэн.

Одоо мөрдөгдөж буй ЭХ-ийн² 13.1-р зүйлийн дагуу хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэж байна.

ТОДОРХОЙЛОЛТ:

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах

1. Биеийг нь үнэлүүдлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. хүч хэд, жирэмсэн эмэгтэйд мэдсээр байж;

2.2. хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;

2.3. Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг:

3.1. байнга тогтвортой;

¹ Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай, УДШ-ийн тогтоол, 2008.03.26 <https://www.legalinfo.mn/law/details/657?lawid=657>

² Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2015, <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

3.2.зохион байгуулалттай гэмт бү лэг ү йлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хү ртэл хугацаагаар, эсхү л бү х насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Хү ү хдийн эсрэг энэ гэмт хэргийг ү йлдсэнд тооцоход энэ зү йлийн 1 дэх хэсэгт заасан аргаар ү йлдсэн байхыг шаардахгү й.

-Энэ гэмт хэргийг ү йлдсэнд тооцоход хохирогч ө ө рийг нь энэ зү йлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг ө ө рө ө зө вшө ө рсө н эсэх нь гэмт хэргийн зү йлчлэлд нө лө ө лө хгү й.

НЭР ТОМЬЁО	ТАЙЛБАР
Хү н худалдаалах	тодорхой тө лбө ртэйгө ө р (мө нгө авах, эд хө рө нгө болон тү ү нийг ө мчлө х эрхээр солилцох г.м) эсхү л ямар нэгэн ү ү ргийн гү йцэтгэлд тооцож (ө рө нд ө гө х г.м) хү нийг бусад хү мү ү сийн мэдэлд бү р мө сө н буюу тодорхой хугацаагаар шилжү ү лэхийг ойлгоно.
Ашиг олох зорилгоор	хү н худалдаалах замаар ө ө ртө ө болон бусад этгээдэд эд хө рө нгийн болон эд хө рө нгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг
Хү ч хэрэглэсэн, хү ч хэрэглэхээр заналхийлсэн	Улсын Дээд шү ү хийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний ө дрийн 41 дү гээр тогтоолын 1.4-г зааснаар
Хууран мэхэлсэн	ү гээр буюу ү йлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхү л зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг тө ө рө гдү ү лэхийг Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.
Эмзэг байдлыг нь далимдуулсан	хохирогчийн эдийн засаг, эрү ү л мэнд болон хө гжлийн бэрхшээлтэй байдал, гэр бү лийн таагү й орчин, тү ү нчлэн амьдрал ахуйн бусад хү нд байдал зэргийг ашигласан байхыг
Элсү ү лсэн	хү нийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сү рдү ү лэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа ү йлдлийг хэлнэ. Хү н худалдаалах гэмт хэргийг ү йлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргү й болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зө вшө ө рү ү лэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.
Тээвэрлэсэн	хү н худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хү нийг нэг газраас нө гө ө д бү х тө рлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зө ө вө рлө хө ө с гадна уг ажиллагаанд бү х талын дэмжлэг туслалцаа ү зү ү лэхийг ойлгоно. Хү н худалдаалж байгаа этгээд ө ө рө ө тээвэрлэсэн бол энэ нь тү ү ний гэмт ү йлдлийн нэг хэсэг болно.

Дамжуулсан	хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.
Орогнуулсан	хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.
Хүлээн авсан	худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.
Эрх мэдлээ урвуулан ашиглах	хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.
Эрхшээлдээ байгаа	эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно.
Хил давуулан	хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар, эсхүл хуурамч буюу хууль ёсоор олж авсан баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна. Хүнийг хил давуулан худалдаалахдаа хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
Хүнд хор уршиг учирсан	хүнийг худалдаалахтай шууд холбоотойгоор амьнас нь хохирсон, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.
Биеийг нь үнэлүүлэх	хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.
Бэлгийн хүчирхийлэлд оруулах	биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан, бэлгийн дур хүслээс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно. Өрийн дарамтад оруулах зэргээр биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.
Албадан хөдөлмөр хийлгэх	хүнийг хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.
Боолчлох	эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүндээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно

Боолчлолтой төстэй байлгах	ижил нөхцөлд	хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.
Эд ашиглах	эрхтнийг нь авч	хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүлс, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ

Бэлгийн мөжлөг болон бэлгийн боолчлол

Хэрэв насанд хүрсэн хүн албан шахалтаар, хүч хэрэглэхээр айлган сүрдүүлсэн тул, хууран мэхлэн, хүч хэрэглэх болон эдгээрийн алийг хэрэглэсний улмаас биеэ үнэлэх байдалд орсон бол ХХГХ-ийн хохирогчоор тооцно. Энэ тохиолдолд хохирогчдыг элсүүлсэн, орогнуулсан, тээвэрлэсэн, нийлүүлсэн, нуун далдалсан, худалдан авсан, худалдсан болон дээрх бүх зорилгоор тодорхой этгээдийг өөртөө хадгалсан үйлдэл хийсэн этгээдийг насанд хүрсэн хүнийг бэлгийн мөжлөг, бэлгийн боолчлолд өртүүлсэн бол хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцно.

Бэлгийн мөжлөг болон бэлгийн боолчлол нь зарим тохиолдолд гэмт этгээд хохирогчдод тэднийг авчрах үед гарсан зардал, тэднийг авчрахын тулд зарцуулсан зардал, түүнчлэн тэднийг зарах үед гарсан зардлаа төлгөх мэтээр хууль бусаар өөрд оруулж, энэхүү өөрөө төлсөн тохиолдолд өөрсдийг нь чөлөөтэй явуулна хэмээн амлах, хүч хэрэглэн биеийг нь үнэлэх явдлаар үйлдэгддэг. Түүнчлэн хохирогч хэдийгээр анхнаасаа биеэ үнэлэх зорилготой байсан боловч ийнхүү биеэ үнэлэхээр зөвшөөрснийх нь дараа тэднийг сэтгэл зүйн хувьд дарамтлах, биед нь хүч хэрэглэх замаар биеийг нь үнэлүүлэх тохиолдлууд олон байдаг бөгөөд үүнийг мөн адил ХХГХ-ийн хохирогч гэж авч үзнэ.

Албадан хөдөлмөрлүүлэх мөжлөг

Албадан хөдөлмөр буюу хөдөлмөр мөжлөг нь хүч хэрэглэн болон бие махбодид нь халдах, сэтгэл зүйн албадлага үзүүлэх, хууль тогтоомжоор айлган сүрдүүлэх, хууран мэхлэх болон бусад албадлагын арга хэрэглэн элсүүлэх, орогнуулах, тээвэрлэх, нийлүүлэх болон эзэмших гэх зэргээр бусдаар хөдөлмөр эрхлүүлсэн явдлыг ойлгоно.

Хэрэв тухайн ажилтан дээрх байдлаар хөдөлмөр мөжлөгт өртсөн бол түүний ажиллахаар зөвшөөрсөн эсэхээс үл хамааран тухайн хүнийг ХХГХ-ийн хохирогчоор, түүнийг авч ажиллуулсан ажил олгогчийг ХХГХ үйлдсэн гэм буруутанд тооцно. Хэдийгээр шилжин суурьшигч болон бусад шилжин ирсэн хүмүүс ихэвчлэн энэ гэмт хэргийн хохирогч болдог боловч зарим тохиолдолд иргэд өөрийн оршин суугаа газарт албадан хөдөлмөрийн золиос болох тохиолдол байдаг.

Барьцааны хөдөлмөр ба өрийн барьцаа

Бэлгийн мөжлөг болон бэлгийн боолчлол, түүнчлэн албадан хөдөлмөр эрхлүүлэхээр бусдад хүч хэрэглэж буй нэг хэлбэр нь хохирогчдыг барьцаанд болон өөрд оруулах явдал юм. Зарим тохиолдолд хохирогчид зориудаар болон тохиолдлоор үүссэн өрийг дарах зорилгоор хүн худалдаалдаг этгээдэд болон зуучлагч этгээдийн мэдэлд ажилладаг. Гэмт

этгээдү ү д хохирогчид зуучлалын хө лс тө лө х ү ү рэг ногдуулах, хэт ө ндө р хү ү тооцох, аль болох ө рө ө тө лж чадахгүй байдалд хү ргэх буюу ө рө ө тө лө х боломжгүй болгох зэрэг арга хэрэглэн ө рийн барьцаанд оруулдаг. Иймэрхүү нө хцө л байдал нь тухайн хохирогчийн эрх зүйн байдал нь ажил олгогчоос шууд хамааралтай байдаг тү р зуурын ажил эрхлэлтэй шууд холбоотой байгаа ү ед голдуу тохиолддог бө гө ө д энэ нө хцө лд ажил олгогчийн эсрэг гомдол гаргаж чаддаггүй.

Хү ү хдийн тэвчишгүй хө дө лмө р


Хэдийгээр хү ү хдү ү д тодорхой хэмжээгээр ажил эрхлэх эрхтэй байдаг боловч заримдаа тэднийг боолын болон боолчлолтой адил нө хцө л байдалд ажиллуулах тохиолдол гардаг. Хэрэв хү ү хэд ө ө рийн гэр бү лийн гишүү н бус хү ний хараан дор, ө ө рийн гэр бү лийн гишүү н бус хү ний ашиг тусын тө лө ө , чө лө ө тэй орхин явах эрхгүйгээр гуйлга гуйх зэрэг ажил хийж байвал тү ү нийг хү ү хдийн тэвчишгүй хө дө лмө р эрхлэлт гэнэ. Хү ү хдийн тэвчишгүй хө дө лмө рийн эсрэг уламжлалт арга хэмжээг цаашид улам ө ргө жү ү лж тэдэнд боловсрол олгох, нө хө н сэргээх аргуудыг мө н ашиглах хэрэгтэй. Тө р засгийн зү гээс хү ү хдийн тэвчишгүй хө дө лмө рийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх захиргааны аргын нэг нь хү ү хдийг боолчлолоос чө лө ө лснийхө ө дараа боолчилж байсан этгээдэд эрү ү гийн ял шийтгэл ногдуулах явдал юм.

СЭДЭВ 2 МОНГОЛ УЛС ДАХЬ ХХГХ-ийн НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН

Монгол Улс хүний наймааны эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсноор уг гэмт үзэгдэлтэй тууштай тэмцэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн бөгөөд хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй орны тоонд багтаж буйн хувьд ийм төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн хууль тогтоох бодлогын хүрээнд зохицуулж, тодорхой алхамуудыг хийж эхлээд цөөнгүй жилийг үдэж байгаа ч ХХГХ-тэй тэмцэх, түүнийг таслан зогсоох нь Монгол улсад тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

Монголд албан ёсоор мэдэгдэж байгаагаар 2001 онд хүн худалдаалах гэмт хэргийн 1 гаралт байсан бол 2018 оны байдлаар 300 гаруй хэрэг бүртгэгдэж, шалгагдсан байна. Гэвч энэ нь бодит байдлыг харуулсан тоо биш юм.


Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх хуулийн байгууллагын 2001-2017 оны статистик мэдээллээс үзэхэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлд заасан Хүн худалдаалах (113 дугаар зүйл) 161 гэмт хэрэг, Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах (124 дүгээр зүйл) 227 гэмт хэрэг тус тус цагдаагийн байгууллагад бүртгэгдэн шалгагдсан.³



³ Монгол улсын гэмт хэргийн цагаан ном, 2018

Хүн худалдаалах гэмт хэрэг нь нууц, далд аргаар үйлдэгддэг, хохирогчийг хамгаалах тогтолцоо сул байгаагаас гэмт хэргийн хохирогч нь уг гэмт хэргийн талаар мэдээлдэггүй зэргээс шалтгаалан хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэргийн тоо цөөн, гэмт хэргийн статистик тоо бодит бус байна.⁴ Мөн энэ төрлийн гэмт хэргийн талаар нэг мөр ойлголтгүй, гэмт хэргийг мөрдөх арга зүй дутмаг, хохирогч, гэрчийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй зэргээс шалтгаалан хүн худалдаалах гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй, бүртгэгдсэн ч шүүхээр хянан шийдвэрлэгдэхгүй, улмаар хэрэгсэхгүй болох, шүүхээс хэргийн зүйлчлэлийг өөрчилж, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр хянан шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байна. Учир нь хүн худалдаалах хэргүүд дээс үзэхэд, эмэгтэйчүүдийг биеийг нь үнэлүүлэх болон бусад хэлбэрээр бэлгийн мөглөгт ашигласан байдаг учраас практикт энэ төрлийн гэмт хэргийг биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл гардаг.⁵

ХХГХ-ийн шийдвэрлэлт 2000-2017 он, ЦЕГ, ШЕЗ-ийн тоо
мэдээ



Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн тоо нь ЦБ-д бүртгэгдэж шалгагдсан хэргийн тооноос маш их зөрүүтэй байгаа нь энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал 2005-2017 онд цагдаагийн байгууллага 127 хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэн шалгасан ч шүүхээр 26 хэргийг л эцэслэн шийдвэрлэснээс харахад хэргийн шийдвэрлэлтэнд дорвитой өөрчлөлт орж чадаагүй гэж үзэж болохоор байна.

Хүйсийн тэгш эрхийн төвийн мэдээлснээр 2003 онд хүний наймааны 3 хохирогчид туслалцаа үзүүлж байсан бол 2003-2018 оны байдлаар туслалцаа авсан хохирогчийн тоо 731 болжээ.

⁴ <https://www.legalinfo.mn/annex/details/7908?lawid=12751>

⁵ Монгол улсын гэмт хэргийн цагаан ном 2016, https://cccp.mn/?page_id=4924



Манай улсад хүн худалдаалах гэмт хэрэг нь хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөг, хүний эд эрхтний наймаа, гэр бүл болоход зуучлах, хүн хэд хууль бусаар үрчлэх зэрэг арга, хэлбэрээр үйлдэгдэж байгаа бөгөөд Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгээс хүн худалдаалах гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд тус гэмт хэрэгт бэлгийн мөлжлөгийн хэлбэр зонхилж байна. Тухайлбал, олон нийтийн газраас үйлчлүүлэгч олох, саун, массажны газарт массажист нэрээр халхавчлах болон цэнгээний газар ширээнд үйлчлэн орлого оруулах хэлбэрээр биеэ үнэлэх, үнэлүүлэх ажлыг зохион байгуулах, цахим орчинд зар байршуулан дуудлагаар секс үйлчилгээ үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэх явдал түгээмэл болсон байна. Мөн гадаадад өндөр цалинтай ажилд зуучлах, сургуульд тэтгэлэгтэй суралцуулах, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах зэргээр зар гаргаж, охид, эмэгтэйчүүдийг хуурч мэхлэн гадаад улсад гарган биеийг үнэлүүлж, хилийн чанадад гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна.


ХТЭТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо мэдээнд анализ хийж үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийн ойролцоогоор 71%-ийг бэлгийн мөлжлөг, 22%-ийг хөдөлмөрийн мөлжлөг, 7%-ийг зуучлалын захиалгат гэрлэлт эзэлж байна. Гэвч XXГХ нь нуугдмал далд үйлдэгддэг учир бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлтэд тулгуурлан өссөн эсхүл буурсан гэсэн дүгнэлтийг шууд өгөх боломжгүй юм. Монгол улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа Хятад-Монголын хилийн эргэн тойронд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдлийг өссөн нэмэгдүүлж байгааг АНУ-ын Төрийн департаментийн 2018 оны тайланд дурджээ⁶.

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ:

Бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт ихэвчлэн охид, залуу эмэгтэйчүүд өртдөг байна. Манай улс дотроо 13-18 насны насанд хүрээгүй охидыг зохион байгуулалттайгаар биеийг үнэлүүлэх, 18-35 насны эмэгтэйчүүдийг хилийн чанадад бэлгийн мөлжлөгт өртүүлж байна. Судлагдсан эрүүгийн хэргүүдээс үзэхэд 30 хувь нь 18-21 насны, 20 хувь нь 21-26 насны, 11 хувь нь насанд хүрээгүй эмэгтэйчүүд

⁶ <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

байна⁷. Хилийн чанадад бэлгийн мө лжлө гт ө ртө гчид ихэнхдээ БНХАУ-ын хот, мужууд, Ө мнө д Солонгос, Япон, Макао, Малайз, Турк руу чиглэж байна⁸.



Хү ний наймаачид гол тө лө в орлого багатай ядуу айл, эсвэл ө нчин ө рө ө сө н, араас нь эрж хайх татлаа тү лхээгү й, хө ө цө лдө ж явах боломжгү й, архидалт, хү чирхийлэлтэй гэр бү лийн 16-35 насны охид, эмэгтэйчү ү дийг сонгохыг чухалчилж, массажны газар, буудал, бар, караоке клубү ү дэд хү чээр ажиллуулж, зохион байгуулалттайгаар хү чээр биеийг нь ү нэлү ү лэн мө лждө г.

2010 оны байдлаар бэлгийн мө лжлө гт ө ртө гсдийн 95.6% нь анх 16 настайдаа хохирогч болсон байна.⁹ Насанд хү рээгү й хү мү ү с, залуу эмэгтэйчү ү дийн дотор ядуу ө рхийн хү ү хдү ү д, ялангуяа хө дө ө нө ө с хотод шилжин ирэгчид илү ү эмзэг байна.¹⁰ Эмэгтэйчү ү д, охид уул уурхайн компаниудыг Хятадын хилтэй холбодог нү ү рс тээвэрлэх зам дагуу хил нэвтрэхээр хү лээж буй жолооч нарт болон уул уурхайн жижиг тосгон, хотууд дахь шө нийн цэнгээний газруудад биеэ ү нэлж бэлгийн мө лжлө гт ө ртө х эрсдэл мө н ө ндө р байна. Уул уурхайд ажиллаж буй ажилчид урт хугацааны ээлжийн гарааны ү еэр ү р хү ү хдээ гэртээ орхисноор тэд бэлгийн мө лжлө гт ө ртө х ө ндө р эрсдэлд орж байна¹¹. Шү ү хээр амжилттай шийдвэрлэгдсэн хү н худалдаалах хэргү ү д бү гд дотоодод болон гадаадад хү чээр биеийг нь ү нэлү ү лж, бэлгийн мө лжлө гийн зорилгоор ү йлдэгдсэн хэргү ү д байсан.

⁷ Хү ний эрхийн ээлжит дү гнэлт хэлэлцү ү лэгт бэлтгэх Монголын тө рийн бус байгууллагын форум 2010 он

⁸ Ibid.

⁹ NSO 2010 in T. Begzsuren and D. Aldar. 2014.

¹⁰ HSPSC. 2012. *Final Report: Program to Combat Human Trafficking in Mongolia. Supported by SDC. January.*

¹¹ <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

АЛБАДАН ХӨ ДӨ ЛМӨ РЛҮ Ү ЛЖ МӨ ЛЖИХ:

Хө дө лмө рийн мө лжлө гийн зорилгоор хү н худалдаалах гэмт хэрэгт эмэгтэйчү ү дээс гадна эрэгтэйчү ү д ө ртө х хандлагатай байна. Иргэдийг хуурамч зар сурталчилгаанаас гадна ажиллах хү ч зуучлах нэртэй компани болон хувь хү н иргэдийг хил давуулан бү лгээр нь хө дө лмө рийг нь мө лжих зорилгоор дотоодод болон БНСУ, БНЧУ, Турк, Казакстан болон хө рш орнуудаар дамжуулан гуравдагч улс орнууд руу худалдаалдах хэрэг гарч байна.¹² Албадан хө дө лмө р эрхлэгчдийн зам Монгол улсаас Турк, Казахстан, Норвеги, Швед рү ү ¹³ чиглэгдсэн байсан. 2003-2018 оны байдлаар ХТЭТ-д 158 хү н хө дө лмө рийн мө лжлө гийн хэлбэрээр хү н худалдаалах гэмт хэрэгт ө ртө н, туслалцаа дэмжлэг авсны 74.6% (118) эрэгтэй, 2.6% (4) насанд хү рээгү й эрэгтэй хү ү хэд байсан байна.

Мө н хү ү хдийг албан бус секторт хү чээр хө дө лмө р эрхлү ү лж хурдан морь унуулах, уран нугараачаар ажиллуулах, гэрийн ү йлчлэгч хийлгэх, мал маллуулах, гуйлга гуйлгах, хог тү ү лгэх г.м хө дө лмө р мө лжлө гийн хэргү ү д бү ртгэгдэж байгаа ч шү ү хээр ХХГХ бус, ө ө р тө рлийн гэмт хэргээр зү йлчилж ял шийтгэл оногдуулдаг. Хилээр нү ү рс зө ө ж буй ачааны машины жолооч нарын паспортыг тээврийн хэрэгслийн барьцаа болгож хурааж авдаг нь тэднийг мө лжлө гт ө ртө х болзошгү й байдал хү ргэж байна. Тү ү нчлэн бага насны хү ү хдү ү д бичил уурхайтай холбоотойгоор албадан хө дө лмө р эрхлэлт болон бэлгийн мө лжлө гт ө ртө ж байна¹⁴. Монгол улсад ө нө ө г хү ртэл албадан хө дө лмө рлү ү лж мө лжих зорилгоор хү н худалдаалсан хэрэг шү ү хээр нэг ч шийдвэрлэгдээгү й бө гө ө д энэ талаар хийгдсэн судалгаа, мэдээлэл ч хомс байна.

ЗУУЧЛАЛЫН ЗАХИАЛГАТ ГЭРЛЭЛТ:

Монгол Улсад “Гэр бү л зуучлал”-ын нэрийдлээр охид, эмэгтэйчү ү дийг гадаадын иргэдтэй тодорхой тө лбө ртэйгээр гэрлү ү лэх ү йл ажиллагаа 2003 оноос эхлэн ө ргө н хү рээтэй ө рнө сө н байдаг. 2007 он гэхэд монголчуудын гадаад хү нтэй гэрлэгсдийн тоо 446 хү нээр буюу 54.1%-иар ө сө ж, тэдгээрийн 90-95%-ийг эмэгтэйчү ү д эзэлсний ихэнх нь буюу 70% нь БНСУ-ын иргэдтэй гэр бү л болсон байна. Судалгаанаас харахад хууль бус гэрлэлт зуучлалын компани, хувь хү мү ү сээр зуучлуулсан иргэдийн олонхи нь харийн нутагт очиж, хү чирхийлэл дарамтад ө ртө ж, байнгын боолчлолын байдалд орон, эрх ашиг нь зө рчигдө ж хү н худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байдаг байна. Хү йсийн тэгш эрхийн тө вд 45, Хү ний эрх, хө гжил тө вд 2 иргэн зуучлалын захиалгат гэрлэлт хэлбэрээр хү н худалдаалах гэмт хэрэгт ө ртө ж, туслалцаа дэмжлэг авчээ.

Монгол эмэгтэйчү ү дийн дийлэнх нь БНСУ, Япон, БНХАУ, ХБНГУ, АНУ зэрэг хү н худалдаалах болон бисэ ү нэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хү лээн авагч улсын иргэдтэй гэрлэсэн байгаагаас ү зэхэд, эмэгтэйчү ү д “Гадаадын иргэдтэй гэр бү л болоход зуучилиа” гэсэн зарын дагуу гэмт этгээдү ү дэд хууран мэхлэгдан худалдаалагдсан байхыг ү гү йсгэх аргагү й.

¹²Хү йсийн тэгш эрхийн тө в, Швейцарийн хө гжлийн агентлэг, Хү ний аюулгү й байдлын судалгааны тө в, Нийслэлийн тагнуулын газар. (2009)

¹³ Ibid.

¹⁴ <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2018-trafficking-persons-report-mn/>

ГАДААДЫН ИРГЭД ХҮНИЙ НАЙМААНД ӨРТӨЖ БУЙ АСУУДАЛ:

Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэгт гадаадын иргэд өртөх хандлага ажиглагдаж эхэлсэн. Тухайлбал, Монгол Улсын чинээлэг гэр бүлүүд Филиппин зэрэг Зүүн Өмнөд Азийн орнуудаас гэрийн үйлчлэгчээр ажиллуулахаар эмэгтэйчүүдийг олноор авчрах болсон. Монголд Филиппин улсаас нэг гэрийн үйлчлэгч эмэгтэйг авчрахад 1200 орчим ам.долларын зардал гарах тооцоог “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-аас хийсэн бөгөөд Монгол гэр бүлүүд гэрийн үйлчлэгч эмэгтэйг 4000 ам.доллар төлөхийг шаардаж, бичиг баримтыг нь барьцаалан, амралтгүй олон цагаар ажиллуулдаг, сүүлдээ мөргөхийг хүртэл хориглодог талаар тус төвд хандсан Филиппин улсын 5 иргэн өгүүлжээ.

Манай улсад уул уурхай, барилгын салбар эрчимтэй хөгжихийн зэрэгцээ гадаадаас ажиллах хүч авах явдал жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй байна. Зарим барилгын компани, иргэд дээрх орнуудын иргэдийг ажиллуулж, улмаар цалин өгөхгүй, эсвэл тохиролцсоноосоо хэт бага цалин өгөх явдал гарах болсон. Тухайлбал, “Бэрэн” ХХК-д гэрээгээр барилга угсралтын ажил гүйцэтгэж байсан БНХАУ-ын иргэдийн цалинг олон сараар нь тус компани олгоогүйн улмаас тэдгээр иргэд Чингисийн тапбайд эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахаар завдсан тул цалинг нь олгожээ¹⁵.

ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН, ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ:

2002 онд ЭХ-нд шинэ төрлийн гэмт хэрэгт тооцон “Хүн худалдах, худалдан авах” гэсэн тусдаа зохицуулалтыг хуулинд тусгасан ч хуулийн зохицуулалт хангалтгүй байснаас 2002-2008 онд шүүхээр хүн худалдаалах зүйлчлэлийн дагуу зургаан хэрэгл шүүхээр шийдвэрлэгдсэн¹⁶. 2008 оноос эхлэн ЭХ-нд НҮБ-ын Палермогийн протоколд дөрхүүлсэн өөрчлөлийг оруулж ирсний үр дүнд хэргийн шийдвэрлэлтэнд бага зэргийн ахиц гарч 2009-2017 онд 20 хэргийг шүүхээр шийдвэрлэжээ.

2011 онд хүн худалдаалахтай холбоотой бие даасан хууль, 2006 оноос эхлэн 2 дахь удаагийн Үндэсний хөтөлбөрөө батлан хэрэгжүүлж байгаа. Мөн эрүүгийн хуулийн 13.1-р зүйлд¹⁷ хүн худалдаалсан нь тогтоогдвол 15 хүртэлх жилээр хорих ял оноохоор хуульчилсан. Түүнчлэн зохион байгуулалттай гэмт бүлэг уг хэргийг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсвэл бүх насаар хорих ял шийтгэнэ гэж заажээ. Төрийн зүгээс эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр анхаарч байгаа боловч энэ төрлийн хохирогчдод үзүүлэх хамгаалах үйлчилгээг бүрэн үзүүлэх нөөц боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл буурахгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой бус, албан хаагчид нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар нэгдмэл ойлголтгүй, байгууллага хоорондын хамтын ажиллагаа байхгүй, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн байдал дутмаг байгаатай холбоотой байна.

¹⁵ Монгол улсын гэмт хэргийн цагаан ном 2016, https://cccp.mn/?page_id=4924

¹⁶ “Монгол улс дахь ХХГХ-ийн зураглал” 2010 он, Хүйсийн тэгш эрх төв, ШХА, хуудас

¹⁷ <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

Хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттайгаар үндэстэн дамнан үйлдэгддэг тул энэ төрлийн гэмт хэргээс урьчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан тогтоосны үндсэн дээр уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, арга хэлбэрийг шинэчлэх шаардлагатай байна.¹⁸

¹⁸ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр 2016-2020 он, <https://www.legalinfo.mn/annex/details/7908?lawid=12751>